



ЗҮҮНБҮРЭН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум  
Цагаан Эрэг II баг  
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040  
E-mail: Selenge@audit.gov.mn

2020.09.30 № СА-2020/04-НА-21  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Зүүнбүрэн сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох Зүүнбүрэн сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөвдийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

• 018020587

## Дүгнэлт

Зүүнбүрэн сумын Ардчилсан намын хорооны Зүүнбүрэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Зүүнбүрэн сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр  
1..10.. хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Зүүнбүрэн сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**УРИА: ӨРХИЙН ӨСӨЛТӨӨС ЗҮҮНБҮРЭН СУМЫН ХӨГЖИЛ**


Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Зүүнбүрэн сумын иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг **ЭРХЭМ ЗОРИЛГО** болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2020-2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд **“ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО”** мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.



## НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ



### 1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Хүүхэд залуучуудыг хөгжүүлэх "СЭЛЭНГЭ STEAM" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. /Шинжлэх ухаан, технологи, инженер, урлаг, математик хөгжил/
- 1.1.3 Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлнэ.
- 1.1.4 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

### 1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулж, эх болон нярайн эндэгдэлгүй ажиллана.
- 1.2.2 Сумын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.
- 1.2.3 Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- 1.2.4 Архидалт, хар тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл зүйн өвчлөлийн шалтгааныг судалж урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулна.
- 1.2.5 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдлыг оновчтой зохион байгуулж, үр дүнг тооцдог болно.
- 1.2.6 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.2.7 Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлнэ.
- 1.2.8 Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, тарималжуулж, үржүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- 1.2.9 Эмийн хэрэглээ, хүнсний аюулгүй байдлын хяналтыг сайжруулна.
- 1.2.10 Сумын хэмжээнд нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоогоор хангаж, бодлогоор дэмжиж ажиллана.

### 1.3 Хүн амын өсөлт, хөгжил

- 1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлж дэмжиж ажиллана.
- 1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг бүрдүүлнэ.



1.3.3 Сумын төвд хүүхэд харах үйлчилгээ гэр цэцэрлэгийг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

1.3.4 Хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

#### 1.4 Ажлын байр хөдөлмөр эрхлэлт

1.4.1 Сумын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлнэ.

1.4.2 Хөдөлмөрийн зах зээл дээр эрэлтийн судалж хэрэгцээтэй байгаа ажил, мэргэжлийн чиглэлээр суралцаж байгаа оюутныг бодлогоор дэмжин ажиллана.

1.4.3 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг бодлогоор дэмжинэ.

1.4.4 Орон нутагт гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.)-ийг бүрдүүлнэ.

#### 1.5 Нийгмийн хамгаалал

1.5.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлнэ.

1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.

1.5.3 Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж, асрамжийн үйлчилгээг төрөлжүүлж, ажиллах нөхцөл бололцоог бодлогоор дэмжинэ.

#### 1.6 Соёл, урлаг, спорт

1.6.1 Уламжлалт өв соёлоо бодлогоор дэмжин соёлын өвийг тоон системд хөрвүүлэн хадгалж, олны хүртээл болгох ажлыг эхлүүлнэ.

1.6.2 Сумынхаа соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан дэмжинэ.

1.6.3 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулна.

1.6.4 Залуу уран бүтээлчдийн уран бүтээлээ олны хүртээл болгох, ур чадвараа хөгжүүлэхэд хамтран ажиллана.

1.6.5 Сайн дурын уран сайханчид болон урлагийн холбоодын үүсгэл санаачилгыг дэмжинэ.

1.6.6 Үндэсний өв соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлэх, сурталчилж өвлүүлэх зорилгоор сумынхаа үндэстэн, ястны язгуур урлагийн наадмыг зохион байгуулж ардын авьяастнуудыг тодруулна.

1.6.7 Соёлын биет болон биет бус өвийг аймгийн баялагт тооцож холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгуулж, үрэгдэж гэмтэх, гадагш алдагдахаас хамгаална.

1.6.8 Биеийн тамир, спортын салбарт аюулгүй ажиллагааны талаар шаардлагатай стандартуудыг нэвтрүүлж ажиллана.

1.6.9 Спортын олон улсын хэмжээний томоохон арга хэмжээ, фестиваль, уралдаан, тэмцээнийг зохион байгуулах, оролцоход дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

1.6.10 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлнэ.



Зүүнбүрэн сумын Ардчилсан нам

- 1.6.11 Бясалгал, хийн дасгал, нийтийн бүжиг, иог, иргэдийн чөлөөт клубуудын үйл ажиллагааг дэмжинэ.
- 1.6.12 Сумын онцлогт тохирсон спортын байгууламжийг нэмэгдүүлнэ.



## ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

### 2.1. Өсөлтийн бодлого

- 2.1.1 ХАА-н үйлдвэрлэлийг төрөлжүүлэн эрчимжүүлнэ.
- 2.1.2 Сумандаа засаглалын зөв механизмыг бүрдүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулж, төрийн албаны мерит зарчмыг баримтална.
- 2.1.3 Байгалийн нөөцийн өгөөжийг иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн бүтээн байгуулалт болон орон нутгийн эдийн засгийн өсөлт, ажил эрхлэлтийг дэмжих тогтвортой олон тулгуурт суурь бий болгоход чиглүүлэх бодлого баримтална.
- 2.1.4 Орон нутагт ажил лах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг санаачилсан гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдыг бүх талаар дэмжиж ажиллана.

### 2.2. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа


- 2.2.1 Жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлж, гарцыг нэмэгдүүлэхэд шаардлагатай мэдээллийн сан үүсгэж, гарааны бизнесийг бодлогоор дэмжин бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн санд байршуулна.
- 2.2.2 Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэл, баялаг бүтээгчдийг дэмжих орон нутгийн бизнес, брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэх зорилгоор үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллана.
- 2.2.3 Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөх үйлчилгээг зохион байгуулна.

### 2.3. Төсөв, санхүү, татварын бодлого

- 2.3.1 Сумын төсвийн зарцуулалтыг зориулалтын дагуу санхүүгийн зөрчилгүй ажиллах зорилт тавин ажиллана.
- 2.3.2 Төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.
- 2.3.3 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.
- 2.3.4 Татварын байцаагч, иргэд, аж ахуй нэгж байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулан, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмждэг чиглэлд шинэчлэлийг хийнэ.
- 2.3.5 Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа гадны аж ахуй нэгжүүдийн орлогын албан татварыг орон нутгийн төсөвт оруулах ажлыг зохион байгуулна.
- 2.3.6 Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлнэ. Санхүүгийн үйлчилгээний хүртээмж, үйлчилгээг ашигласнаар иргэн аж ахуйн нэгжид бий болох ашгийн бодит хэмжээг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалтын арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ.

### 2.4. Хөдөлмөрийн зах зээл

- 2.4.1 Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэхийг дэмжин ажиллана.
- 2.4.2 Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургууль төгсөгчдийг сумандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бололцоог бүрдүүлж ажлын байраар хангах ажлыг зохион байгуулан ажиллана.



## 2.5 Үйлдвэрлэл

- 2.5.1 Хүн амын гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоод хэрэгцээг чанартай хүнсээр хүртээмжтэй хангаж, дотоод зах зээл дэх хүнсний нийлүүлэлтийн сүлжээг бий болгож аюулгүй байдлын тогтолцоог нэвтрүүлэх замаар найдвартай хүнс нийлүүлэгч сум болно.
- 2.5.2 Хүнсний ногоо тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, борлуулалтын сүлжээ бий болгох чиглэлээр Солонгос, Япон зэрэг өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг орон нутагтаа нутагшуулж ажиллана.
- 2.5.3 Төв суурин газрын нийтийн орон сууцны оршин суугчдад хүнсний хэрэгцээгээ хангах, өрхийн орлогоо нэмэгдүүлэх зорилгоор дөрвөн улирлын төвлөрсөн хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжиж, ногоо тариалах газрын асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.
- 2.5.4 Мэдээллийн технологийг ашиглан мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд тавих хяналтыг сайжруулна.
- 2.5.5 Бүх нийтийн хүнсний боловсролыг дээшлүүлэх, хоол хүнс, шим тэжээлийн чанар, аюулгүй байдлыг эрүүл амьдралын зан үйл, хэвшилтэй нягт уялдуулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.5.6 Хот, суурин газрын хүн амыг эрүүл, чанартай усаар хангах дэд бүтцийг сайжруулна.
- 2.5.7 Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуурыг боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 2.5.8 Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гадны байгууллагуудын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамрагдахад бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.5.9 Орон нутгийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг төрийн бүх байгууллагууд хэрэглэдэг байх журам тогтоож бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.5.10 Төрөөс аж үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэхэд баримтлах бодлогын хүрээнд орон нутагтаа томоохон үйлдвэрлэлийн төслүүдийг эхлүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

## 2.6 Дэд бүтэц

- 2.6.1 Эдийн засгийн өсөлтийн суурь болсон хатуу болон зөөлөн дэд бүтэц (зам тээвэр, эрчим хүч, сэргээгдэх эрчим хүч, усан хангамж, мэдээлэл, харилцаа холбоо)-ийн хөрөнгө оруулалтыг хувийн, төсвийн, болон төр хувийн хэвшлийн түншлэл зэрэг санхүүжилтийн бүхий л төрөл, боломжийг идэвхтэй ашиглана.
- 2.6.2 Иргэдийн санал санаачилгыг дэмжин авто замын шинэчлэлийн ажлыг аймаг, сум, орон нутгийн хөрөнгөөр шийдвэрлүүлэх саналыг боловсруулж холбогдох байгууллагад уламжилна.
- 2.6.3 Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулна.
- 2.6.4 Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ дэд бүтцийг бүрэн барьж байгуулахыг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.



Зүүнбүрэн сумын Ардчилсан нам

2.6.5 Инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлын стандартыг хангуулна.

## 2.7 Барилгын салбар

2.7.1 Сумын төвийн ерөнхий төлөвлөгөө хийж дахин төлөвлөлтийн ажлыг хийж гүйцэтгэхийг холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлнэ.

2.7.2 Барилга, байгууламжийн насжилтыг тогтоож мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулж, дахин төлөвлөх ажлыг эхлүүлнэ.

2.7.3 Орон нутагт хотжилтыг дэмжих зорилгоор барилгын материалын жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.7.4 Сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт залны барилга байгууламжид тавигдах нэгдсэн стандарт шаардлагыг мөрдүүлнэ.

2.7.5 Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам шат бүхий хэрэгсэл суулгах ажлыг зохион байгуулна.

## 2.8 Аялал жуулчлал

2.8.1 Спортын, эрүүл мэндийн, эко-туризм, ургамал, амьтан судлал, түүх соёлын дурсгалт газруудын судалгаа шинжилгээ экстрим /адал явдалт/ аялал зэрэг аялал жуулчлалын төрөл хэлбэрүүдийг дэмжинэ.

2.8.2 Төрөөс аялал жуулчлалын талаар баримтлах бодлогод тусгагдсан байгалийн онцгой үзэсгэлэнт газар, тусгай хамгаалалттай газруудад хэрэгжих олон улсын байгууллагын болон хувийн хэвшлийн санаачилга хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийг бодлогоор дэмжинэ.

## 2.9 Шинжлэх ухаан технологи, мэдээлэл, харилцаа

2.9.1 Орон нутагт өндөр хурдны интернэтийн сүлжээг өргөтгөж, 5G технологийг нэвтрүүлэх ажлыг мэргэжлийн хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

2.9.2 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгож түгээлтийг нэмэгдүүлнэ.

2.9.3 Багш нарын цахим боловсролын ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

2.9.4 Иргэдэд зориулсан цахим боловсролын төвийн үйл ажиллагааг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлнэ.

## 2.10 Эрчим хүч

2.10.1 Сумын шугам сүлжээг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэхийг Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХХК-тай хамтран хэрэгжүүлнэ.


2.10.2 Шинэ бүтээн байгуулалт, шинэ суурьшлын бүсийг цахилгааны эрчим хүчээр найдвартай хангах техник, технологийн боломжийг бүрдүүлнэ.

2.10.3 Шинэ зууны малчин хөтөлбөр хэрэгжүүлж малчин өрхүүдийг хүчин чадал өндөртэй цахилгаан хэрэгсэл ашиглах боломжоор хангаж, бодлогоор дэмжинэ.

## ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

### 3.1 Орон нутгийн хөгжил





- 3.1.1 Эдийн засгийн бие даасан байдлыг хангах, төсөв бүрдүүлэх, зарцуулах эрхийг нэмэгдүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн шийдвэрлүүлнэ.
- 3.1.2 Байгалийн баялгаас улсын төсөвт орж байгаа орлогын тодорхой хувийг орон нутагт нь шууд хуваарилдаг тогтолцоог бүрдүүлэх санал боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.
- 3.1.3 Орон нутгийн төрийн худалдан авалтын үйл ажиллагааг сумандаа сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг, шалгарсан байгууллагууд тухайн орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах бодлого баримтална.
- 3.1.4 Орон нутгийн аж ахуй нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.
- 3.1.5 Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.
- 3.2. **“Шинэ хөдөө” хөтөлбөр**
  - 3.2.1 Уламжлалт мал, аж ахуйн гаралтай түүхий эд ноос, ноолуур, арьс шир, махыг малчдын оролцоотой анхан шатны түүхий эдийн тордолгооны цэгт бэлтгэн өндөр түвшний технологийн үйлдвэрт эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дотоодын болон гадаад зах зээл дээр өрсөлдөх үнээр борлуулах боломжийг бүрдүүлнэ.
  - 3.2.2 Газар тариалангийн үйлдвэрлэлд техникийн шинэчлэл хийж, баталгаат сортын үрийн хангамж, ургамал хөрс хамгаалалт, услалтын систем барих зэрэг агро техникийн цогц бодлогыг баримталж аж ахуйн нэгж байгууллагатай хамтран ажиллана.
  - 3.2.3 Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмжээр хангаж, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.3 **Бэлчээр ашиглалт**
  - 3.3.1 Малын гаралтай түүхий эдийг бэлтгэх хэрэгжүүлнэ.
  - 3.3.2 Бэлчээрийн татварын орлогыг тухайн орон нутгийн төсвөөр дамжуулан бэлчээрийн нөхөн сэргээлтэд зориулах саналыг боловсруулан уламжилна.
  - 3.3.3 Бэлчээр ашиглалтын байдалд хариуцлага тооцох журам баталж, сумын бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.
  - 3.3.4 Малчдын хамтын оролцоонд тулгуурлан газар нутгийн 40 орчим хувийг эзэлж байгаа бэлчээр нутгийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийн сэргээх бодлогыг баримтлан ажиллана.
  - 3.3.5 Малчдыг бүлэг, хэсгийн зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.
  - 3.3.6 Сумын хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож усан хангамжийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ.
  - 3.3.7 Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар малчдын бүлэг, хоршоонд эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.
  - 3.3.8 Малыг тооноос чанарт шилжүүлэх, бэлчээрийн даацыг тохируулж, хамгаалж, сайжруулсан малчин өрх, бүлэг, хэсгийг дэмжинэ.

### 3.4 Газар тариалан

- 3.4.1 Газар тариаланг урамшуулах бодлогын хүрээнд үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллана.
- 3.4.2 Үр тариа болон ургамал хамгаалах химийн бодис, бордоо био бэлдмэлээр үржил шим нь буурсан тариалангийн талбайн ургацыг нэмэгдүүлэхийг дэмжинэ.
- 3.4.3 Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хувийн аж ахуй нэгж байгууллагатай хамтран хөгжүүлэх бодлогыг баримтлан ажиллана.
- 3.4.4 Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи, инновац нэвтрүүлнэ.
- 3.4.5 Ургамал хамгаалалтын орчин үеийг арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.4.6 Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 3.4.7 Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж импортыг орлох чанартай, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх бодлого барин ажиллана.

### 3.5 Мал аж ахуй

- 3.5.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэн мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого бүхий хүчтэй дундаж давхаргыг тэлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 3.5.2 Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 3.5.3 Малын үүлдэр омог, угшлыг баталгаажуулж төрөлжсөн хэлбэрээр өсгөж үржүүлнэ.
- 3.5.4 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээ хүртээмжийг чанартай болгож хяналтыг сайжруулна.
- 3.5.5 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малын вакцин, туулгад бүрэн хамруулан эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.
- 3.5.6 Арьс шир, түүхий эдийн анхан шатны үйлдвэрлэлийг бодлогоор дэмжин боловсруулалт хийгдсэн бүтэгдэхүүнийг гадаад дотоодын үйлдвэрүүдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулна.

## ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ ЗҮҮНБҮРЭНЧҮҮД

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авилгаас ангид ажиллах чадавхтай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн, хүртээмжтэй, цахим нийтийн албыг бэхжүүлэх шинэчлэл хийнэ.

### 4.1 Иргэндээ үйлчилдэг засаглал



Зүүнбүрэн сумын Ардчилсан нам

- 4.1.1 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 4.1.2 Төсвийн зарцуулалтад тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлнэ.
- 4.1.3 Иргэд гарын үсэг цуглуулж, тодорхой асуудлыг хөндөж дэвшүүлсэн тохиолдолд сумын ИТХ -аар хэлэлдэг болно.
- 4.1.4 Албан хаагчдын ёс зүй, зан харилцаанд тавих олон нийтийн хяналтыг бий болгоно.
- 4.1.5 Хуульчийн мэргэжилтэй зөвлөх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага иргэнтэй хамтран иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.



## 4.2 Хөгжлийг дэмждэг хууль

- 4.2.1 Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж, олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай, үр дүнтэй хүргэх ажлыг зохион байгуулна.
- 4.2.2 Иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд зөвлөн туслах чиглэлийн ажлыг зохион байгуулж ажиллана.
- 4.2.3 Аймаг сумаас зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой ил тод нээлттэй болгоно.

## ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН ЗҮҮНБҮРЭНЧҮҮД

### 5.1 Амар тайван амьдрах орчныг бүрдүүлнэ


- 5.1.1 Иргэн бүрийн аюулгүй байдлаа хангахад хэрэгтэй мэдлэг мэдээллийг нийгэмд түгээж, иргэдийн оролцоог дэмжинэ.
- 5.1.2 Төрийн тусгай албан хаагчдын ар гэрийн аюулгүй байдал, нийгмийн асуудлыг шийдэхэд анхаарч ажиллана.
- 5.1.3 Иргэдэд аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах арга ажиллагааны хүртээмж, үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.
- 5.1.4 Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисоос хамааралтай, донтогч болсон хүнд эмнэлгийн, сэтгэл зүйн болон нийгмийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллана.
- 5.1.5 Нас, хүйс, хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт, хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.1.6 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хангах, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог хангаж дэмжлэг үзүүлнэ.

## ЗУРГАА. ЭКОСИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

- 6.1.1 Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, иргэдийн амьдралын чанар, хүртээмжийг сайжруулна.

Зүүнбүрэн сумын Ардчилсан нам

- 6.1.2 Хөв цөөрөм байгуулж, усны нөөцийг хуримтлуулах замаар бэлчээр усжуулах, усалгаатай газар тариаланг хөгжүүлнэ.
- 6.1.3 Бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 6.1.4 Уур амьсгал, цаг уурын сөрөг нөлөөллийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулан ажиллана.
- 6.1.5 Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглаж хоггүй сум болох ажлыг зохион байгуулна.
- 6.1.6 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлж, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 6.1.7 Ус, хөрс, бэлчээрийг хамгаалах, цөлжилттэй тэмцэх асуудлыг нэгдсэн бодлогоор дэмжинэ.
- 6.1.8 Усалгаатай газар тариалангийн салбарт гүний усны ашиглалтыг хязгаарлаж, гадаргын усны ашиглалтыг түлхүү дэмжинэ.
- 6.1.9 Байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн байнгын өсөлтийг хангасан ногоон эдийн засагт суурилсан хөгжлийн үе шат руу шилжих ажлыг зохион байгуулна.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗҮҮНБҮРЭН СУМЫН  
АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО**

